



## “МОНГОЛЫН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛ-2014” ЧУУЛГАУУЛЗАЛТ MONGOLIA MINERAL EXPLORATION ROUNDUP 2014

### “МОНГОЛЫН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛ-2014” ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Монгол улсын газар шинжээчид буюу геологичид 2013 онд хийж гүйцэтгэсэн геологи-хайгуулын судалгааны ажлын талаар харилцан мэдээлэл солилцон, судалгаа шинжилгээний арга аргачлалын алдаа, оноо, амжилт бүтээлийн талаар ярилцан шинжлэх ухааны онол, ажлын дадлагыг уралдуулан харилцан туршлагаа солилцон шинэлэг, онцлог төслүүдийн үр дүнгийн танилцуулга хийгдэн тэдгээрт хөрөнгө оруулалт татах, улмаар өөрийн судалгааны ажлын онцлогийг олон нийтэд таниуулан мэдрүүлж, төрийн бодлогод санал бодлоо нэгтгэн нэмэрлэх үүднээс энэ жилийн “МОНГОЛЫН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛ-2014” олон улсын геологчдын чуулга уулзалтанд оролцогдоос дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. УИХ-аас баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын (2014-2025 он) баримт бичигт тусгагдсан геологийн асуудлуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх,
2. Бодлогын баримт бичигт тусгагдсан Монгол улсын геологийн судалгааны үйл ажиллагааг нэгтгэн, тогтвортой хөгжлийг хангах үүрэгбүхий “Монголын Үндэсний Геологийн Алба”-ыг байгуулснаар эх орны нутаг дэвсгэрийн геологийн судалгааг цогцоор нь иж бүрнээр явуулах боломжтойг тэмдэглэж, тус албаны бүтцийг яаралтай тодорхой болгон байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх, уг алба нь санхүүгийн хувьд чадамжтай, чадварлаг хүний нөөцтэй, шинжилгээ судалгааны орчин үеийн багаж тоног төхөөрөмж бүхий лабораторитой, геологийн судалгаа явуулах суурь нэгжтэй, мэдээллийн нэгдсэн төвтэй олон улсын жишигт нийцсэн алба байхаар төлөвлөгдсөн байна.
3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг төрөөс хориглосонтой уялдан геологи-хайгуулын судалгааны ажлын хэмжээ эрс буурч ажилгүйдэл нэмэгдэж буйг тэмдэглэн, геологийн судалгаанд хувийн хөрөнгө өрхийх хайгуулын ажлыг төрөөс дэмжих бодлогын хүрээнд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг төрөөс тогтоосон газарт олгож эхлэх,
4. Геологи-эрдэс баялгийн салбарт хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшсэн, зөвлөхүүдийголон улсын түвшинд бэлтгэх, улмаар тэдгээрийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх ажлыг эхлүүлэх,
5. Геологийн бүх төрөл, үе шатны ажилд оролцож буй геологчид, геофизикчид, гидрогоеологичид, өрөмдөгчид, лабораторийн ажилтнуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, судалгааны ажлын чанар чансааг шинжлэх ухааны үндэслэлтэй бөгөөд оновчтой арга аргачлалаар хийх зорилгоор геологийн судалгаа, эрэл-хайгуул, геофизик, гидрогоеологи, өрөмдлөг, дээжлэлт-сорьцлолт, лабораторийн шинжилгээний ажлын аргачлал, стандартыг боловсруулж эхлэх, энэ ажлын хүрээнд юуны өмнө хатуу ашигт малтмалын нөөцийн тооцоо бүхий ордын техник эдийн засгийн үндэслэлийн нөхцөлд тавих аргачилсан зааврыг боловсруулах,
6. Геологийн судалгаанд зарцуулах санхүүжилтийг “улсын төсөвт хуваарилсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30 хүртэл хувийг геологи, уул уурхайн салбарын санхүүжилтэд хуваарилна” гэсэн ашигт малтмалын тухай хуулийн 58.3-р заалтыг 30 хувь гэж өөрчлөн хэрэгжүүлэх, мөн хуулийн 58, 59-р зүйлд заасан ашиглалтын ба хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн төлбөрийн сум, аймаг орон нутагт оногдох төлбөрийн хувийг тухайн орон нутгийн төсөв дээр нэмэн шилжүүлэх заалтыг амьдралд хэрэгжүүлэх нь орон нутаг, аж ахуйн нэгж, төр хоорондын уялдаа сайжирч ажил үйлс бүтэмжтэй, орон нутагт хөрөнгө оруулалт ихсэж, үр ашиг харилцан нэмэгдэж хүн ам хөгжин дэвжинэ.

7. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйлажиллагаа хэт их оройтож, шийдвэр нь удаашралтай байгаагаас үүдэн судалгааны ажлын чанарт муугаар нөлөөлж буйг онцгой анхаарах, геологийн судалгааны ажлын онцлогоос хамааран сонгон шалгаруулалтыг оны өмнө ил тод, нээлттэй хийдэг болгох,
8. Улсын төсвийн болон хувийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, орон нутгийн иргэдтэй зөвшилцөхэд Төрийн оролцоо чухал шаардлагатай байгааг онцгойлон анхаарч орон нутагт чиглэсэн үйлажиллагааг идэвхижуулэх, хэвлэл мэдээллээр дамжуулан салбарын бодлогыг олон нийтэд зөв таниулах ажлыг хамтын хүчээр хийх,
9. Гол, мөрний урсац бүрэлдэхэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотой төрийн зохицуулалтыг хийж дуусгах,

Төр, орон нутгийн засаг захиргааны болон иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, ард иргэдхэн боловч Монгол улсын ерөнхийлөгчийн хэлсэн “том төрөөс ухаалаг төррүү, ухаалаг төр бол хуулиа биелүүлдэг төр мөн” гэснийгсанан хамтран ажиллаж Монгол улсын хөгжлийн тулгуур салбар болох эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжлийг ханган хуулийн хүрээнд хариуцлагатай ажиллахыг уриалж байна.

#### **ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧИД**

**Улаанбаатар хот, 2014-3-21**